



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2026/193/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № СЭА-2026/193/НА-СТА-ТШЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ШААМАР СУМЫН НЭГДҮГЭЭР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Ц.БОЛОРМАА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 3,749.5 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн,
- Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, аймгийн түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр тооцон 646.3 мянган төгрөгийг олгосон,
- Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 826.9 мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон,

- Цалингийн зардлаас нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 4,968.3 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Аудитаар илэрсэн дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Сэлэнгэ аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 505,719.2 мянган төгрөгийн барилгын их засварыг капиталжуулж бүртгэсэн, Шаамар сумын ЗДТГ-аас 5,700.0 мянган төгрөгийн ухаалаг дэлгэц, Боловсролын ерөнхий газраас 24,516.0 мянган төгрөгийн угаалгын машин, стем сургалтын хэрэглэгдэхүүн, эцэг эхийн хандиваар 5,169.1 мянган төгрөгийн гадаа тоглоомыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус цэцэрлэг нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 10 зорилтын хүрээнд 83 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Тод-руулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	38,760,022.15	21,268,179.57
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		38,760,022.15	21,268,179.57
3121	Төгрөг		38,760,022.15	21,268,179.57
31211	Төрийн сангийн харилцах		38,760,022.15	21,268,179.57
33	АВЛАГА	5		324,768.59
331	Ажиллагчидтай холбогдсон авлага			324,768.59
35	БАРАА МАТЕРИАЛ	6	38,557,620.72	41,587,590.72
354	Хангамжийн материал		38,557,620.72	41,587,590.72
3541	Бичиг хэргийн материал		155,000.00	155,000.00
3542	Аж ахуйн материал		23,537,260.72	24,018,270.72
3546	Хүнсний материал		1,392,325.00	2,657,825.00
3547	Бусад хангамжийн материал		13,473,035.00	14,756,495.00
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		77,317,642.87	63,180,538.88
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	290,778,560.79	805,328,693.63
392	Биет хөрөнгө		280,274,560.79	794,824,693.63
39201	Барилга, байгууламж, орон сууц		273,357,400.00	779,076,577.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		(43,161,694.56)	(58,388,251.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		54,438,100.00	73,758,300.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		(39,742,876.38)	(40,364,859.59)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		19,817,306.28	29,870,881.28
39208	Хуримтлагдсан элэгдэл		(7,989,696.28)	(10,517,356.36)
39209	Зам, гүүрийн байгууламж		6,477,900.00	6,477,900.00
39214	Бусад үндсэн хөрөнгө		42,986,893.00	48,155,993.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(26,200,622.27)	(33,430,141.34)
39217	Ном		291,851.00	185,651.00
393	Биет бус хөрөнгө		10,504,000.00	10,504,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө		10,504,000.00	10,504,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		290,778,560.79	805,328,693.63
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		368,096,203.66	868,509,232.51
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9	1,399,810.22	20,907,172.49
413	Өглөг		1,399,810.22	20,907,172.49
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		1,399,810.22	16,754,039.49
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг			4,072,000.00
4136	Бусад өглөг			81,133.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг			81,133.00
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,399,810.22	20,907,172.49
51	Засгийн газрын хувь оролцоо		366,696,393.44	847,602,060.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		72,194,770.87	72,194,770.87
512	Хуримтлагдсан үр дүн		18,183,999.00	499,089,665.58
5121	Өмнөх үеийн үр дүн		18,183,999.00	18,183,999.00
5122	Тайлант үеийн үр дүн			480,905,666.58
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		276,317,623.57	276,317,623.57
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		366,696,393.44	847,602,060.02
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		368,096,203.66	868,509,232.51

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Тод-руулга	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		618,192,683.59	743,026,198.35
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		574,718,900.00	698,491,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		574,718,900.00	698,491,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		43,473,783.59	44,534,398.35
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		43,473,783.59	44,534,398.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		12,584,000.00	549,517,452.00
120	Нийтлэг татварын бус орлого		12,584,000.00	549,517,452.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого			70,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих			70,000.00
120009	Бусад орлого		35,000.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		12,185,000.00	541,104,252.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		364,000.00	8,343,200.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	630,776,683.59	1,292,543,650.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ		670,372,845.26	811,615,483.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		663,537,645.26	811,615,483.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		489,120,265.33	600,336,985.41
210101	Үндсэн цалин		332,500,549.85	398,285,870.95
210102	Нэмэгдэл		146,988,165.48	174,403,664.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт			2,200,000.00
210104	Урамшуулал		9,631,550.00	25,447,450.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		61,684,617.04	75,736,950.85
210201	Тэтгэврийн даатгал		43,389,185.00	54,529,283.80
210202	Тэтгэмжийн даатгал		5,071,385.49	6,366,119.45
210203	ҮОМШӨ-ний даатгал		2,434,527.25	3,008,027.79
210204	Ажилгүйдлийн даатгал		2,141,169.93	2,341,365.43
210205	Эрүүл мэндийн даатгал		8,648,349.37	9,492,154.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		38,973,783.59	38,534,398.35
210301	Гэрэл, цахилгаан		6,876,800.79	6,437,416.56
210302	Түлш, халаалт		32,096,982.80	32,096,981.79
2104	Хангамж, бараа материалын зардал		3,786,228.50	3,181,880.00
210401	Бичиг хэрэг		849,800.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		260,700.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		362,500.00	
210408	Бараа материал актальсны зардал		2,313,228.50	3,181,880.00
2105	Нормативт зардал		39,174,250.00	38,718,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		183,775.00	
210502	Хоол, хүнс		38,990,475.00	38,718,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		4,500,000.00	6,000,000.00
210604	Урсгал засвар		4,500,000.00	6,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,621,000.00	1,410,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		331,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,290,000.00	1,410,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		24,677,500.80	47,697,069.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		5,464,200.00	15,156,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх			746,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол		19,213,300.80	31,793,819.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		6,835,200.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг		6,835,200.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		6,835,200.00	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	670,372,845.26	811,615,483.77
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		(39,596,161.67)	480,928,166.58
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		1,363,583.85	22,500.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		1,363,583.85	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал			22,500.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		(1,363,583.85)	(22,500.00)
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		(40,959,745.52)	480,905,666.58

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	618,227,683.59	743,096,198.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,000.00	70,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	35,000.00	70,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		70,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		70,000.00
120009	Бусад орлого	35,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	618,192,683.59	743,026,198.35
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	574,718,900.00	698,491,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	574,718,900.00	698,491,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	43,473,783.59	44,534,398.35
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	43,473,783.59	44,534,398.35
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	656,572,257.02	760,669,173.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	656,572,257.02	760,669,173.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	649,737,057.02	760,669,173.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	488,113,348.43	590,935,075.58
210101	Үндсэн цалин	316,058,384.75	372,807,600.00
210102	Нэмэгдэл	162,129,113.68	192,467,440.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт		2,200,000.00
210104	Урамшуулал	9,925,850.00	23,460,035.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,237,300.00	70,109,400.00
210201	Тэтгэврийн даатгал	41,641,400.00	47,678,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,899,000.00	5,609,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,449,500.00	2,805,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,449,500.00	2,805,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,797,900.00	11,210,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,973,783.59	38,534,398.35
210301	Гэрэл, цахилгаан	6,876,800.79	6,221,600.00
210302	Түлш, халаалт	32,096,982.80	32,096,981.79
210303	Цэвэр, бохир ус		215,816.56
2105	Нормативт зардал	38,064,650.00	35,911,500.00
210502	Хоол, хүнс	38,064,650.00	35,911,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,500,000.00	6,000,000.00
210604	Урсгал засвар	4,500,000.00	6,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,621,000.00	2,392,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,621,000.00	2,392,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,226,975.00	16,786,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,137,375.00	12,776,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,089,600.00	4,009,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,835,200.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,835,200.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,835,200.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(38,344,573.43)	(17,572,975.58)
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(38,344,573.43)	(17,572,975.58)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		38,760,022.15
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		21,268,179.57

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,194,770.87	276,317,623.57	18,183,999.00	366,696,393.44
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			480,905,666.58	480,905,666.58
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,194,770.87	276,317,623.57	499,089,665.58	847,602,060.02

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	781,210,300.00	743,026,198.35	38,184,101.65	95.1
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	736,214,700.00	698,491,800.00	37,722,900.00	94.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	698,814,400.00	698,491,800.00	322,600.00	100.0
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	37,400,300.00			
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	44,995,600.00	44,534,398.35	461,201.65	99.0
132001	Орон нутгийн төсвөөс	44,995,600.00	44,534,398.35	461,201.65	99.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		70,000.00	(70,000.00)	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		70,000.00	(70,000.00)	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	781,210,300.00	743,096,198.35	38,114,101.65	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	781,210,300.00	760,669,173.93	20,541,126.07	97.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	773,682,500.00	760,669,173.93	13,013,326.07	98.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	598,113,500.00	590,935,075.58	7,178,424.42	98.8
210101	Үндсэн цалин	372,807,600.00	372,807,600.00		100.0
210102	Нэмэгдэл	201,463,300.00	192,467,440.48	8,995,859.52	95.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт		-	(2,200,000.00)	
210104	Урамшуулал	23,842,600.00	23,460,035.10	382,564.90	98.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,223,200.00	70,109,400.00	4,113,800.00	94.5
210201	Тэтгэврийн даатгал	50,369,000.00	47,678,200.00	2,690,800.00	94.7
210202	Тэтгэмжийн даатгал	5,963,500.00	5,609,400.00	354,100.00	94.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,981,800.00	2,805,500.00	176,300.00	94.1
210204	Ажилгүйдлийн даатгал	2,981,800.00	2,805,500.00	176,300.00	94.1
210205	Эрүүл мэндийн даатгал	11,927,100.00	11,210,800.00	716,300.00	94.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,995,600.00	38,534,398.35	461,201.65	98.8
210301	Гэрэл, цахилгаан	6,221,600.00	6,221,600.00		100.0

210302	Түлш, халаалт	32,097,000.00	32,096,981.79	18.21	100.0
210303	Цэвэр, бохир ус	677,000.00	215,816.56	461,183.44	31.9
2105	Нормативт зардал	36,918,100.00	35,911,500.00	1,006,600.00	97.3
210502	Хоол, хүнс	36,918,100.00	35,911,500.00	1,006,600.00	97.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	6,000,000.00		100.0
210604	Урсгал засвар	6,000,000.00	6,000,000.00		100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,392,700.00	2,392,700.00		100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,392,700.00	2,392,700.00		100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,039,400.00	16,786,100.00	253,300.00	98.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,945,300.00	12,776,350.00	168,950.00	98.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,094,100.00	4,009,750.00	84,350.00	97.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,527,800.00		7,527,800.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,527,800.00		7,527,800.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,527,800.00		7,527,800.00	
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	781,210,300.00	760,669,173.93	20,541,126.07	97.4
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		38,760,022.15	(38,760,022.15)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		21,268,179.57	(21,268,179.57)	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
3	Төсвийн байгууллага	1	1		
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22	22		
6	Удирдах ажилтан	1	1		
7	Гүйцэтгэх ажилтан	10	10		
8	Үйлчлэх ажилтан	11	11		

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 15,031.0 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Үр дүнгийн тайланд 1,179.4 мянган төгрөгийн бараа үйлчилгээний бусад зардлыг бичиг хэргийн /210401/ зардлаар тайлагнасан,
- Үр дүнгийн тайланд 10,669.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалаар тайлагнасан,
- Үр дүнгийн тайланд 3,181.9 мянган төгрөгийн акталсан бараа материалыг бараа үйлчилгээний бусад /210901/ зардлаар тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга”-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой...”, санхүүгийн тайлангийн “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **23,550.3** мянган төгрөгийн 5 зөрчил<sup>1</sup> илэрснээс 646.3 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 9,544.6 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 13,359.4 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **23,550.3** мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,487.2 мянган төгрөгөөр давсан тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### **3.1 Төлбөрийн акт**

1. Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, аймгийн түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр 4 багшид тус бүр 20.0-25.0 хувиар тооцон 646.3 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь *“Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь”, “сумын түвшинд 15 хувь”, “аймгийн түвшинд 20 хувь”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### **3.2 Албан шаардлага**

1. Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс тогооч Н.Булганд 826.9 мянган төгрөгийн цалинг давхардуулан бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх *“Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Биеэр бүрэн эдлээгүй ээлжийн амралтыг нөхөн эдлүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Цалин хөлс, нэмэгдэл урамшлын батлагдсан төсвөөс ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 4,968.3 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”* Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан *“Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

3. Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 3,749.5 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Нягтлан бодох

бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нийгмийн даатгалын тайлагналтай холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Нийгмийн даатгалын тайланд 13,359.4 мянган төгрөгийн цалинг буруу тайлагнасан. Тухайлбал хүүхэд асрах чөлөөтэй байгаа албан хаагчийг ажилласнаар тайлагнаж, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтны цалингийн даатгуулагчийн кодыг буруу тайлагнасан, нийгмийн даатгалд 1 ажилтны цалинг орхигдуулсан зэргээр өр төлбөр үүсэх эрсдэлийг бий болгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө” гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын тайланд албан хаагчдын цалин хөлс, кодыг үнэн зөв тайлагнаж байх зөвлөмж хүргүүлээ

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үр дүнгийн тайланд зардлыг буруу ангилан бүртгэсэн.	1	1,179.4			1	1,179.4	1	1,179.4				

Үр дүнгийн тайланд орлогыг буруу ангилан бүртгэсэн.	1	10,699.8			1	10,669.8	1	10,669.8				
Үр дүнгийн тайланд зардлыг буруу ангилан бүртгэсэн.	1	3,181.8			1	3,181.8	1	3,181.8				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>15,031.0</b>			<b>3</b>	<b>15,031.0</b>	<b>3</b>	<b>15,031.0</b>			1	13,359.4

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ур чадварын нэмэгдлийг нотлох дэмжих баримтгүйгээр олгосон.	1	646.3	1	646.3								
Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс давхардуулан бодож олгосон.	1	826.8			1	826.8						
Зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй	1	4,968.3			1	4,968.3						
Тооцооллын алдаанаас шалтгаалж, тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс өр төлбөр үүсгэсэн	1	3,749.5			1	3,749.5						
Нийгмийн даатгалд буруу тайлагнасан	1	13,359.4					1	13,359.4				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>23,550.3</b>	<b>1</b>	<b>646.3</b>	<b>3</b>	<b>9,544.6</b>	<b>1</b>	<b>13,359.4</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансанд мэдээлбэл зохих 171 мэдээллээс	1	-							1	-		

10 хугацаа хоцроосон								
Дүн	1	-					1	-
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Дүн								
Нийт дүн								

**ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		